



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ХЭРЛЭНБАЯН-УЛААН ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ**

2025 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 4/02

Хэрлэнбаян-Улаан тосгон

**Өмч хамгаалах байнгын зөвлөл
байгуулах тухай**

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэхь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоол, Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь :

1. Өмч хамгаалах байнгын зөвлөлийг доорхи бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллуулсугай.

Зөвлөлийн ахлагч : Н.Гэрэлтуяа /Эх баригч бага эмч /
Нарийн бичгийн дарга Б.Уранчимэг/ Ахлах сувилагч /
Гишүүд: П.Амгаланзаяа /Сувилагч/
П.Мөнгөнтуяа /Тогооч /
Ц.Оюун-Эрдэнэ /Эд аж ахуйн нярав /

2.Өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүд Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 04, 2022 оны 04 тогтоолыг дагуу журам, зааврыг баримтлан эмнэлгийн хэмжээнд бүртгэлд байгаа өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, алдаа зөрчлийг арилгах, сургалт зохион байгуулах .

3.Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах дүрэм, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж ажиллахыг өмч хамгаалах байнгын зөвлөлийн ахлагч болон гишүүдэд даалгасугай.

4.Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагаанд ахиц гаргаж, үйл ажиллагааг улирал тутам тайлагнаж байхыг өмч хамгаалах байнгын зөвлөлийн даргад үүрэг болгосугай .

ЭРХЛЭГЧ  Н.МӨНХТУЯА

